



**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар

8/79

Улаанбаатар хот

**Ёс зүйн дэд хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 3.8, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Ёс зүйн дэд хороонд доорх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг даалгасугай.

2.1.Ёс зүйн дэд хороо нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах

2.2.Төрийн албаны хууль, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж шийдвэрийг удирдлага болгон хувь хүн, ажилтан албан хаагчдын нууцыг хадгалж, шударга байдлыг ханган, нотлох баримтад үндэслэн улс төрөөс хараат бусаар зохион байгуулах;

2.3.Газрын ажилтан, албан хаагчдад ёс зүйн мэдээлэл сургалт хийж, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах;

2.4.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах

2.5.Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан мэдээг хууль тогтоомжийн дагуу Газрын даргад танилцуулж тайлагнах

3.Ёс зүйн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгосугай.

4.Дээрх урамшууллыг холбогдох зардлаас тооцон гаргахыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Б.Даваасүрэн)-д зөвшөөрсүгэй.


5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/49 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.УУТАНБАЯР

. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны
өдрийн 11/29 дугаар тушаалын хавсралт



ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН:

Хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичиг:

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга

Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга

Дотоод хяналтын албаны дарга

Хөрөнгө оруулалт, худалдан авах
ажиллагааны албаны дарга

Тохижилт үйлчилгээний албаны дарга

Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн

Дотоод ажил, хүний нөөцийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6.7 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт, 4.8, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Ёс зүйн хорооноос ТОГТООХ нь

- "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- Засгийн газар, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.
- Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газар, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд даалгасугай.
- Тогтоолын хэрэгжидтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

ДАРГА Ц.АМАРТӨГС



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.8 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ыг нэгдүгээр, “Ёс зүйн мэдээллийн цахим сангийн бүрдлийн жагсаалт”-ыг хоёрдугаар, “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлийн маяг”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газар, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороод, томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын алба /Н.Ганбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

2400026

“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН




2026 оны 01 дүгээр сарын 05

НЭГ. Товч танилцуулга
Газрын даргын 2025 оны А/79 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Ёс зүйн хорооны даргаар Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Гишүүнээр Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөд Ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн, Дотоод хяналтын албаны дарга Г.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Их-Амгалан, Тохижилт үйлчилгээний албаны дарга Б.Нарантуяа, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Э.Баярмаа, Нарийн бичгээр Дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Байгаль нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
“Төрийн албан хаагчийн ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлуулан, байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг газрын Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтарч “Манлайлал ба байгууллагын стрессийн менежмент” сургалтыг Авто бааз, Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба, Тохижилт үйлчилгээний албаны ажлын байруудад зохион байгуулж, 120 ажилтан албан хаагчийг хамрууллаа. Захирагчийн ажлын албанаас харьяа газруудын Ёсзүйн хорооны дарга, нарийн бичиг нарт зориулсан “Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль”-ийн 3 цагийн сургалтад 10 дугаар сарын 29-нд зохион байгуулж, тус сургалтад Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Дотоод ажил хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Байгаль нар хамрагдсан. Хоёрдогч түүхий эд цуглуулагч иргэдэд зориулсан сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Үүнд: Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүлэгийн лектор Илтгэгч Б.Бандицэрэн /Чило/ илтгэл тавьж, түүхий эд цуглуулагч /ченж/ нартай хамтран, хог түүгч иргэдэд мэдээлэл хүргэх сургалтыг зохион байгуулж, сургалтад 183 хүн оролцлоо. “Гарц-Шийдэл” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар СХД-ийн Засаг даргын Тамгын газартай хамтран Сонгинохайрхан дүүргийн 26, 41 дүгээр хорооны нутаг дэвсгэрт амьдарч байгаа айл өрхийн гишүүд, хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, 36-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн ойр орчмын хөдөлмөрийн насны иргэдийг ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, бичил зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулах, орлого нэмэгдүүлэх боломж олгох олон асуудлаар хэлэлцэж, арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа.
2.2.Томилсон эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан “Нийслэлийн төсөв асуудал, шийдэл: Иргэдийн хяналт” сэдэвт хэлэлцүүлгийг 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, дээрх хэлэлцүүлэгт газрын дарга Г.Ууганбаяр оролцов. 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн НИТХ-ын Засаглал, эрх зүйн хорооны хэлэлцүүлэг, арга хэмжээнд Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нар оролцсон.
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Газрын даргын А/79 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны чиг үүргийг баталж: - Төрийн албаны хууль, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж шийдвэрийг удирдлага болгон хувь хүн, ажилтан албан хаагчдын нууцыг хадгалж, шударга байдлыг ханган, нотлох баримтанд үндэслэн улс төрөөс хараат бусаар зохион байгуулах;

- Газрын ажилтан, албан хаагчдад ёс зүйн мэдээлэл сургалт хийж, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах;
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах
- Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан мэдээг хууль тогтоомжийн дагуу Газрын даргад танилцуулж тайлагнах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэлээ.

Гарсан үр дүн	Бэрхшээл
Нийт ажилтан албан хаагчдын дунд байгууллагын болон хувь хүний харилцаа хандлага, ажилдаа чин сэтгэлээсээ хандах хандлагууд өөрчлөгдсөн зэрэг зэрэг үзүүлэлттэй байлаа.	
Санал	
Байгууллагын нийт ажилтан албан хаагчдад Удирдлагын академиас сургалт авах	

Сургалтын фото зураг



БАТАЛГААЖУУЛАГТ
ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
ДАРГА  Г.УУГАНБАЯР

ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БААСАНБАТ

ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Н.БАЙГАЛЬ

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар сарын ...-ний өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1		Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо				4	4	40
4	Томилхох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЕЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0,8	0,8
Хэсгийн оноо				3	2,8	20,8
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЕЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	-	-
Хэсгийн оноо				3	2	20
Үнэлгээний нийт оноо, хувь				10	8,8	88

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} \cdot 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.
[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.
[9] ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.



**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026 оны 01 дүгээр сарын 02

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Төсөв	Хариуцах эзэн
Нэг. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалтыг тогтмолжуулах, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг нээмгдүүлэх зорилтын хүрээнд					
1	Газрын хэмжээнд нийт ажилтан албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалтыг холбогдох газартай хамтран зохион байгуулах	Жилдээ 2 удаа	224 ажилтан албан хаагч хамрагдсан байна.	3,000,000	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага зөвлөмж боловсруулж, видео шторк бэлтгэж, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээх	Жилдээ 4 удаа	Байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	-	
3	Ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах	Жилдээ 2 удаа	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байна.	2,000,000	
Хоёр.Төрийн албан хаагчийн Ёс зүйн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиглэлээр ёс зүйн хороог бэхжүүлэх ажлын хүрээнд					
4	Ёс зүйн зөчлийн талаархи гомдол мэдээллийг хүлээн авч, хянан шалгах, дүгнэлт зөвлөмж гаргаж тайлагнах	Тухай бүр	Дүгнэлт, зөвлөмж	-	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
5	Ёс зүйн зөрчлийн шатлгаан нөхцлийг судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлсон зөрчлийг бууруулах арга хэмжээг авах	Жилдээ 2 удаа	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажлын тайлан болон ёс зүйн дэд хорооны хийж гүйцэтгэсэн ажлын тайланг олон нийтэд ил тод мэдээлэх	Тухай бүр	Тайланг ил тод мэдээлсэн байна.	-	

ЁСЗҮЙН ДЭД ХОРОО